

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/565/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Цахим актив аудит ХХК-ийн захирал: Л.Амарзаяа Утас: 88501881 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.25 № 04/173
танай _____-ны № _____-т

УЛАМЖЛАЛТ АНАГААХ
УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН
КЛИНИК ТӨВИЙН ЗАХИРАЛ
Х.ГҮРБАЗАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 64,642.8 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байгаа нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 5 дугаар тогтоолуудаар баталсан журамтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн засаг даргын 2000 оны 468 дугаар захирамжаар "Нийслэлийн засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв" болж өөрчлөн зохион байгуулсан бөгөөд 2008 онд Нийслэлийн засаг даргатай менежментийн гэрээ байгуулж "Хангалттай" үнэлгээ авсан тохиолдолд хувьд шилжүүлэх нөхцөлтэй ажиллуулсан байна.

Менежментийн хувьчлал нь Монгол Улсын Их хурлын 2002 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 128 болон 61 дүгээр тогтоол, Нийслэлийн

02003608

C:\Users\zanomene\Desktop\2025\Word\995in\BicMg\2025.02.25\UMDES Clinic.docx

өмч хувьчлалын комисс (НӨХК)-ын 73 дугаар тогтоолуудын дагуу 2008-2011 онд нийт 3 жилийн хугацаатай явагдсан байна.

zНийслэлийн өмч хувьчлалын комиссын 2012 оны 12 дугаар тогтоолоор "Хангалттай", 2014 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн тогтоолоор "Хангалтгүй" гэж дүгнэж гэрээг дуусгавар болгохоор шийдвэрлэсэн байна. Үүнээс шалтгаалан өнөөдрийг хүртэл байгууллагын статус, эрх зүйн хувьд маргаантай байна.

Аудитын гол асуудал

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв нь 2024 онд эм, эмнэлгийн хэрэгслүүд ханган нийлүүлэх болон эмнэлгийн хүнсний материал нийлүүлэх худалдан авах ажиллагааг 11 сард зохион байгуулсан бөгөөд түүнээс өмнөх хугацаанд Нийслэлийн эрүүл мэндийн газраас сонгон шалгаруулсан компаниудтай байгуулсан гэрээний хугацаа дууссан хэдий ч харилцсаар ирсэн байна. Тайлант онд гэрээний шинэчлэл, сунгалт хийгээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан бөгөөд тайлант онд тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй боловч ирээдүйд байгууллагын статус, эрхзүйн орчин өөрчлөгдөхийг үгүйсгээгүй болно. Тиймээс тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагатай байлаа. Үүнд, байгууллагын удирдлагын зүгээс харьяалах дээд шатны байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээ, хэлцэл, түүний хэрэгжилт, дүгнэсэн баримт ирүүлээгүй, тус байгууллагын өмчлөлийн талаарх маргаантай байгаа талаарх баримт бичиг, мөн энэ асуудлаарх хууль, шүүхийн байгууллагаас гарсан шийдвэр зэргийг ирүүлэхийг удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй зэрэг нь тухайн байгууллагын үйл ажиллагааны талаар хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүссэн тул бидний олж авсан нотолгоо, дээрх нөхцөл байдал нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгүүд нь элэгдлээрээ өртгөө нөхсөн, дахин үнэлгээ хийгдээгүй, хөрөнгө оруулалт, санхүүжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан үндсэн хөрөнгийн шинэчлэлт хийгдээгүй, байрны тохижилт, эрүүл мэндийн салбарын технологийн дэвшил зэргээрээ ижил төстэй байгууллага болон эрүүл мэндийн салбарын хөгжлөөс хоцрогдолтой байгаад анхаарал хандуулах шаардлага байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөг)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	335,005,703.96	478,900,901.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,056,812.87	112,108,123.12
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,056,812.87	112,108,123.12
31210	Төгрөг	4,056,812.87	112,108,123.12
33	АВЛАГА	60,081,350.00	105,474,777.04
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	2,639,951.34
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	60,081,350.00	102,834,825.70
35	БАРАА МАТЕРИАЛ	270,867,541.09	261,318,001.30
35100	Түүхий эд материал	141,478,576.09	104,859,247.30
35110	Тусгай зориулалттай материал	19,851,559.64	12,611,177.35
35130	Эм боох материал	121,627,016.45	92,248,069.95
35400	Хангамжийн материал	129,388,965.00	156,458,754.00
35410	Бичиг хэргийн материал	2,955,575.00	3,603,995.00
35420	Аж ахуйн материал	9,958,830.00	9,960,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	302,000.00	302,000.00
35440	Түлш, шатах тослох материал	715,529.00	60,128.00
35450	Барилгын засварын материал	990,000.00	990,000.00
35460	Хүнсний материал	6,506,920.00	27,426,170.00
35470	Бусад хангамжийн материал	107,960,111.00	114,116,111.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,754,316,237.80	1,465,523,180.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,754,316,237.80	1,465,523,180.97
39200	Биет хөрөнгө	1,754,316,237.80	1,465,523,180.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,123,590,800.00	7,123,590,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,752,060,666.48	-6,768,948,399.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,177,266.40	55,177,266.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,177,266.40	-55,177,266.40
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,948,722,059.33	1,948,722,059.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-643,965,849.34	-904,787,682.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,162,072.40	141,162,072.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,512,608.11	-77,596,098.03
39209	Зам, гүүрийн байгууламж	1,295,600.00	1,295,600.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,295,600.00	-1,295,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,767,230.00	7,767,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,386,800.00	-4,386,800.00
39301	Програм хангамж	980,000.00	980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-980,000.00	-980,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,089,321,941.76	1,944,424,082.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,475,919,174.90	2,202,215,273.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,475,919,174.90	2,202,215,273.46
41300	Өглөг	1,475,919,174.90	2,202,215,273.46
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	684,599,866.13	1,170,982,120.08

41360	Бусад өглөг	791,319,308.77	1,031,233,153.38
41361	Байгууллагад төлөх өглөг	789,006,408.77	1,027,210,153.38
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,312,900.00	4,023,000
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	613,402,766.86	-257,791,191.03
51	Засгийн газрын хувь оролцоо	613,402,766.86	-257,791,191.03
51100	Засгийн газрын оруулсан капитал	549,910,480.39	549,910,480.39
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	549,910,480.39	549,910,480.39
51200	Хуримтлагдсан үр дүн	-961,695,536.67	-1,832,889,494.56
51210	Өмнөх үеийн үр дүн	454,802,664.63	-961,695,536.67
51220	Тайлант үеийн үр дүн	-1,416,498,201.30	-871,193,957.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,025,187,823.14	1,025,187,823.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,089,321,941.76	1,944,424,082.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,971,008,789.00	4,653,433,551.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,313,759.00	506,277,287.00
120	Нийтлэг татварын бус орлого	96,313,759.00	228,641,987.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,734,059.00	89,429,335.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,734,059.00	89,429,335.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,579,700.00	32,343,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,874,695,030.00	4,147,156,264.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,874,695,030.00	4,147,156,264.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,874,695,030.00	4,147,156,264.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,387,506,990.30	5,524,627,508.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,387,506,990.30	5,524,627,508.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,387,506,990.30	5,417,196,538.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,679,676,778.70	3,249,310,492.91
210101	Үндсэн цалин	1,613,336,608.96	1,908,382,707.60
210102	Нэмэгдэл	925,030,669.74	1,007,769,872.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	141,309,500.00	115,756,780.00
210104	Урамшуулал	0.00	217,401,133.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	331,091,342.05	392,157,626.41
210201	Тэтгэврийн даатгал	229,153,768.24	275,560,744.78
210202	Тэтгэмжийн даатгал	27,384,907.65	32,149,308.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,976,886.93	19,044,965.84

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

210204	Ажилгүйдлийн даатгал	4,490,904.71	12,863,221.67
210205	Эрүүл мэндийн даатгал	46,084,874.52	52,539,386.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	558,278,290.72	253,025,097.31
210301	Гэрэл, цахилгаан	153,235,404.71	64,184,271.14
210302	Түлш, халаалт	263,939,167.74	82,368,267.48
210303	Цэвэр, бохир ус	141,103,718.27	106,472,558.69
2104	Хангамж, бараа материалын зардал	225,158,112.86	106,176,316.50
210401	Бичиг хэрэг	4,460,100.00	6,770,480.00
210402	Тээвэр, шатахуун	24,905,780.00	14,555,401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,982,020.86	39,979,813.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,718,300.00	35,455,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	75,642,254.00	3,347,800.00
210408	Бараа материал акталсны зардал	61,449,658.00	6,067,522.50
2105	Нормативт зардал	1,233,706,140.94	1,041,866,442.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	596,166,650.94	562,311,292.43
210502	Хоол, хүнс	637,539,490.00	479,555,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,042,000.00	31,293,840.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	350,000.00	3,785,000.00
210604	Урсгал засвар	28,692,000.00	27,508,840.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	1,620,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	1,620,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,230,619.00	44,159,316.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,300,000.00	800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,268,000.00	11,750,000.00
210807	Газрын төлбөр	24,212,619.00	24,609,316.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	450,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,323,706.03	297,587,406.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8,794,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	284,823,706.03	288,793,056.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	107,430,970.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	107,430,970.50
213207	Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		106,030,970.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,400,000.00

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,416,498,201.30	-871,193,957.89
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,416,498,201.30	-871,193,957.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,901,347,739.00	4,578,337,075.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,734,059.00	473,934,287.00
120	Нийтлэг татварын бус орлого	86,734,059.00	196,298,987.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,734,059.00	89,429,335.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,734,059.00	89,429,335.00
120009	Бусад орлого		106,869,652.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	277,635,300.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	0.00	277,635,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,814,613,680.00	4,104,402,788.30
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,814,613,680.00	4,104,402,788.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,814,613,680.00	4,104,402,788.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,916,460,578.60	4,470,285,765.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,916,460,578.60	4,470,285,765.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,916,460,578.60	4,362,854,794.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,318,971,733.61	2,751,662,367.61
210101	Үндсэн цалин	1,313,138,520.70	1,421,652,313.32
210102	Нэмэгдэл	870,639,879.41	996,852,141.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,193,333.50	115,756,780.00
210104	Урамшуулал	0.00	217,401,133.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,547,751.55	436,635,300.00
210201	Тэтгэврийн даатгал	125,411,237.71	436,635,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,069,760.17	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,323,808.25	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,303,958.52	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,438,986.90	0.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	480,613,691.59	387,645,695.64
210301	Гэрэл, цахилгаан	105,849,665.90	110,717,217.65
210302	Түлш, халаалт	241,947,959.24	170,455,919.30
210303	Цэвэр, бохир ус	132,816,066.45	106,472,558.69
2104	Хангамж, бараа материалын зардал	130,166,545.86	85,517,523.00
210401	Бичиг хэрэг	10,111,285.00	7,654,200.00
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	13,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,521,620.86	27,829,813.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,017,580.00	17,093,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,516,060.00	19,040,510.00
2105	Нормативт зардал	748,245,730.99	647,689,453.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250,268,930.99	463,041,153.30
210502	Хоол, хүнс	497,976,800.00	183,808,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	840,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,880,125.00	27,784,555.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	4,785,000.00
210604	Урсгал засвар	69,880,125.00	22,999,555.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,535,000.00	25,919,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	14,100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,268,000.00	9,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	450,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	817,000.00	2,819,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	107,430,970.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	107,430,970,5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	106,030,970,5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,400,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-15,112,839.60	108,051,310.25
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	65,142,700.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,142,700.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,142,700.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,142,700.00	0.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-65,142,700.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-80,255,539.60	108,051,310.25
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,312,352.47	4,056,812.87
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,056,812.87	112,108,123.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Код	Үзүүлэлт	ЗГ-н оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	454,802,664.63	2,029,900,968.16
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	454,802,664.63	2,029,900,968.16
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,416,498,201.30	-1,416,498,201.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	-961,695,536.67	613,402,766.86
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	-961,695,536.67	613,402,766.86
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-871,193,957.89	-871,193,957.89
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	-1,832,889,494.56	-257,791,191.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,091,701,900.00	4,470,285,765.05	378,583,865.05	91.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,091,701,900.00	4,470,285,765.05	378,583,865.05	91.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,091,701,900.00	4,470,285,765.05	378,583,865.05	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,148,430,700.00	2,751,662,367.61	- 603,231,667.61	128.08
210101	Үндсэн цалин	1,950,340,000.00	1,421,652,313.32	528,687,686.68	72.89
210102	Нэмэгдэл	39,149,500.00	996,852,141.27	- 957,702,641.27	2,546.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,158,800.00	115,756,780.00	-27,597,980.00	131.30
210104	Урамшуулал	70,782,400.00	217,401,133.02	- 146,618,733.02	307.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	608,185,500.00	159,000,000.00		
				449,185,500.00	26.14
210201	Тэтгэврийн даатгал	511,408,000.00	159,000,000.00	352,408,000.00	31.09
210202	Тэтгэмжийн даатгал	24,194,400.00		24,194,400.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,097,200.00		12,097,200.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	12,097,200.00		12,097,200.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	48,388,700.00		48,388,700.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	387,680,000.00	387,645,695.64	34,304.36	99.99
210301	Гэрэл, цахилгаан	110,720,000.00	110,717,217.65	2,782.35	100.00
210302	Түлш, халаалт	170,460,000.00	170,455,919.30	4,080.70	100.00
210303	Цэвэр, бохир ус	106,500,000.00	106,472,558.69	27,441.31	99.97
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	87,632,900.00	85,517,523.00	2,115,377.00	97.59
210401	Бичиг хэрэг	8,333,000.00	7,654,200.00	678,800.00	91.85
210402	Тээвэр, шатахуун	15,618,000.00	13,900,000.00	1,718,000.00	89.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	27,548,300.00	27,829,813.00	-281,513.00	101.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,093,000.00	17,093,000.00		100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,040,600.00	19,040,510.00	90.00	100
2105	Нормативт зардал	800,860,500.00	587,608,053.30	213,252,446.70	73.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	613,302,200.00	402,959,753.30	210,342,446.70	65.7

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

210502	Хоол, хүнс	183,808,300.00	183,808,300.00		100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,000.00	840,000.00	2,910,000.00	22.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,153,000.00	27,784,555.00	368,445.00	98.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,153,400.00	4,785,000.00	368,400.00	92.85
210604	Урсгал засвар	22,999,600.00	22,999,555.00	45.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,759,300.00	25,919,900.00	4,839,400.00	84.27
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,500,000.00	14,100,000.00	400,000.00	97.24
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,400,000.00	9,000,000.00	400,000.00	95.74
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,859,300.00	2,819,900.00	4,039,400.00	41.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,700,000.00			
			1,400,000.00	1,300,000.00	51.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,700,000.00			
			1,400,000.00	1,300,000.00	51.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	106,446,800.00	106,030,970.50	415,829.50	99.61
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,700,000.00	1,400,000.00	1,300,000.00	51.85
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,090,345,900.00	4,193,832,123.30	103,486,223.3	111.46
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,010,112,300.00	4,104,402,788.30	-94,290,488.30	102.35
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,010,112,300.00	4,104,402,788.30	-94,290,488.30	102.35
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,233,600.00	89,429,335.00	-9,195,735.00	111.46
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,233,600.00	89,429,335.00	-9,195,735.00	111.46
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,056,812.87	4,056,812.87	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		112,108,123.12	112,108,123.12	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1		100

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

610001	Төсвийн байгууллага	1	1		100
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	145	145		100
620001	Удирдах ажилтан	13	13		100
620002	Гүйцэтгэх ажилтан	77	77		100
620003	Үйлчлэх ажилтан	68	68		100
620004	Гэрээт ажилтан				
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	18620	19459	839	104.5
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	5280	5160	120	99.7
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	13340	14298	958	107.1
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	145	145		100
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13	13		100
650003	Ажлын албаны албан хаагч (АА)				
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	110	110		100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35	35		100
650010	Гэрээт ажилтан				

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,008,153.3 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд төлбөрийн акт тогтоогдсоныг холбогдох ажилтнаас суутган авч төсөвт төвлөрүүлсэн ажил гүйлгээг бүртгэхдээ зардал данс бууруулж алдаатай бүртгэснийг санхүүгийн орлого үр дүнгийн тайланд залруулсан.
- Тайлант оны ХХОАТ-ын үлдэгдлийг тооцоо нийлсэн акттай тулгаж бүртгээгүй, зөрүүтэй бүртгэл хөтөлсөнийг өр төлбөрийн дансанд залруулсан;
- Цахилгааны өглөгийн тооцоо данснаас зардлын данс бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөнг санхүүгийн орлого үр дүнгийн тайланд залруулсан.

удитаар нийт 64,642.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 49,161.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 15,481.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 64,642.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 32,137.0 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөхийг санал болголоо.

5.1 Албан шаардлага

1.Тус байгууллагын гүйцэтгэх захирал Х.Гүрбазар, ерөнхий нягтлан бодогч Л.Байгальмаа нарт өмнөх оны аудитаар НТАГ-ын 2024-02-23-ны өдрийн 104/108104479 дугаар албан шаардлагаар сахилгын шийтгэл хүлээлгэсэн боловч хэрэгжүүлээгүй, түүнчлэн эдгээр 2 албан тушаалтанд тайлант онд үр дүнгийн урамшуулал болох нийт 5.441.1 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл хүлээлгэх албан шаардлага хүргүүллээ.

2.Тус байгууллагын 26 ажилтантай холбоотой хууль, журмаар хүлээн зөвшөөрөгдөөгүй хариуцлагын нэмэгдэл 43,720.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох" журмын 2-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны 382 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох “ журамтай нийцэхгүй байгаа тул зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3. Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн 248 төрлийн 6,438,060,6 сая төгрөгийн балансын үнэтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байгаа нь өнөөгийн бодит үнэ цэнийг илэрхийлж чадахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохин байгуулах удирдах”, 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1.”Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3-т “Дотоодын тооллогын тайлан тэнцлийн дүнг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, санхүү, статистикийн байгууллагатай хамтран улсын хэмжээгээр нэгтгэн гаргах, дутагдсан эд хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэл болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн эд хөрөнгийг шилжүүлэх, борлуулах, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч Засгийн газарт тайлагнана”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үлдэх өртөггүй хөрөнгүүдэд мэргэжлийн байгууллагаар дахин үнэлгээ хийлгэж, тайлан балансад тусгах, алдаа, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт зардлыг төсвийн эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй байна. /Түлш халаалтын зардлаас-цахилгааны зардал 14,081.5 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас - шатахууны зардалд 1,400.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн /

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, үнэн зөв бүртгэж толилуулж байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн 248 төрлийн 6,438,060.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн

тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж, шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунгах, цаашид ашиглах эсэхийг шийдвэрлэх зөвлөмж өгөв.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус эмнэлэгийн 2024 оны жилийн эцсийн тооллогоор газар эзэмших гэрчилгээнүүдийг тооллогод хамруулаагүй, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших гэрчилгээтэй тухайн хөрөнгүүдийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэн авах талаар зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх аудитын акт суутган авч төсөвт төвлөрүүлэхдээ дансны бичилтийг алдаатай бүртгэж Зардал данс бууруулсан.	1	966,7			1	966,7	1	966,7				

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Татварын үлдэгдэл тооцоо зөрүүтэй бүртгэсэн. /ХХОАТ -ын тайлан ТТ-11/	1	527.6			1	527.6	1	527.6				
Цахилгааны өглөгийн тооцоо данснаас зардлын данс бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөн.	1	40,977.6	1	40,977.6			1	40,977.6				
Дүн	3	42,471.9	1	40,977.6	2	1,494.3	3	42,471.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн зарлагыг эдийн засгийн ангилалын дагуу тайлагнаагүй. Түлш халаалтын зардлаас 14,081.50 төгрөгийн цахилгааны зардал, шуудан холбооны зардлаас 1,400.00 төгрөгийн шатахууны зардлуудыг төсвийн зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	1	15,481.5					1	15,481.5				
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 248 төрлийн 6,438.0 мянган төгрөгийн балансын үнэтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байгаа нь өнөөгийн бодит үнэ цэнийг илэрхийлж чадахгүй байна.	1				1							
Тус эмнэлэгийн 2024 оны жилийн эцсийн толлогоор СХД-т байршилтай аж ахуйн зориулалттай 5300м ² , гудамж зориулалттай 4193м ² , ХУД-т байршилтай төмс хүнсний ного тариалах зорижлалттай 21743м ² , нийт 3 газар эзэмших гэрчилгээнүүдийг тооллогод хамруулаагүй, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдаагүй байгаа тул мэргэжлийн байгууллагаар үнэлгээхийлгэж, холбогдох материалуудыг бүрдүүлэн бүртгэх.	1						1					
Тус байгууллагын 26 ажилтантай холбоотой хууль журмаар хүлээн зөвшөөрөгдөөгүй хариуцлагын нэмэгдэл олгосон.	1	43,720.2			1	43,720.2						
Тус байгууллагын 2 албан тушаалтантай холбоотой өмнөх оны аудитын НТАГ-ын 2024-02-23-ны өдрийн 104/108104479, 104/10810479 дугаар албан	1	5,441.1			1	5,441.1			1	1		

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

шаадлагаар сахилгын шийтгэл хүлээлгэсэн байхад тайлант онд үр дүнгийн урамжуулал олгосон.												
Дүн	5	64,642.8			3	49,161.3	2	15,481.5				

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
УАУЭСКТөв нь шилэн дансанда цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний 6,337,722.4 мянган төгрөгийн 186 мэдээлэл байршуулахаас 291,433.5 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй байна.	1	291,433.6								1	1		
Дүн	1	291,433.6								1	1		